



БОДИТ БҮРТГЭЛ АУДИТ ХХК

15172 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
2 дугаар хороо, Их тойруу-15,
Ренталон ХХК-ийн байр 101 тоот
Утас: 8811-8264, 9917-8951
E-mail: boditburtgelaudit@gmail.com

“ПРАЙМ ФАЙНАНШИАЛ
ХОЛДИНГС ” ББСБ-н Удирдлагад

2022. 2. 19 № 22/46
танай _____ -ны № _____ -г

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Аудиторуудын дүгнэлт

Бид энэхүү “ПРАЙМ ФАЙНАНШИАЛ ХОЛДИНГС” ББСБайгууллагын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлан тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр тус байгууллагын санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх байгууллагын санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудыг дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтаагүй мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл аудитын явцад бидний олж авсан ойлголттой нийцэж байгаа эсэх эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм. Дээр дурьдсан горимуудыг гүйцэтгэх явцад энэхүү бусад мэдээлэлтэй холбоотой материаллаг буруу илэрхийлэл илрүүлсэн бол бид тайлагнах шаардлагатай байдаг. Үүнтэй холбоотой тайлагнах аливаа зүйлс байхгүй.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор компанийн удирдлагын хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, толилуулах нь байгууллагын удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудиторуудын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш Монгол Улсын хуулийн этгээд болох та бүхэнд тайлагнах нь бидний хариуцлага юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшиний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог



Захирал:

[Signature] /Х.УНДРАГА/

**" ПРАЙМ ФАЙНАНСИАЛ ХОЛДИНГС" ББСБ-ийн 2021 оны 12 сарын 31-нээрхи
АУДИТЛАГДСАН ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН
БАЛАНС**

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	113,843.0	182,215.5
Нийт зээл /цэвэр/	2,403,328.6	2,383,630.9
Бусад авлага	5,706.1	242,775.6
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага		
Бараа материал		
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,522,877.7	2,808,622.0
Үндсэн хөрөнгө		
Биет бус хөрөнгө	2,400.0	2,400.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,400.0	2,400.0
НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,525,277.7	2,811,022.0
Дансны болон бусад өглөг	2,062.2	6,556.9
Цалингийн өглөг		
Татварын өглөг		
НДШ-ийн өглөг		
Бусад богино хугацаат өр төлбөр		
Урьдчилж орсон орлого		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,062.2	6,556.9
Урт хугацаат өглөг		
Урт хугацаат зээл		227,520.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.0	227,520.0
НИИТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,062.2	234,076.9
Хувьцаат капиталын дүн	2,500,000.0	2,500,000.0
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг		
Дахин үнэлгээний нөөц		
Хуримтлагдсан ашиг, алдагдал	23,215.5	76,945.1
НИИТ ӨМЧИЙН ДҮН	2,523,215.5	2,576,945.1
НИИТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	2,525,277.7	2,811,022.0
Орлогын тайлан	0.0	0.0

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Цэвэр хүүгийн орлого	40,029.7	93,847.7
Хүүгийн зардал	7,800.7	19,906.4
Нийт ашиг	32,229.0	73,941.3
Хүүгийн, Бусад орлого		
Ерөнхий ба удирдлагын зардал	20,447.6	14,241.7
Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал	11,781.4	59,699.6
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал		
Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	11,781.4	59,699.6
Орлогын татварын зардал	1,178.1	5,970.0
Татварын дараах цэвэр ашиг, алдагдал	10,603.3	53,729.6

Мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	40,029.7	93,847.6
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	28,248.3	34,148.1
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	11,781.4	59,699.5
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн орлого		8,673.0
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	1,500,035.0	
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-1,500,035.0	8,673.0
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-1,488,253.6	68,372.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,602,096.6	113,843.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	113,843.0	182,215.5

0.0

БОДИТ БҮРТГЭЛ

Баталсан:

АУДИТ

Захирал

ХХК

УЛААНБААТАР ХОТ

(Х.Ундрага)